



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Өлзий-Орших овогтой Сумъяабаатарыг Гадаад хэргийн яамны захиалгаар АНУ-ын Бриджпортын их сургуулийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр, Ядамсүрэн овогтой Хуланг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Стратфорд их сургуулийн магистрантурт боловсролын эдийн засгийн чиглэлээр, Сандаг овогтой Тунгалагтамирыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар АНУ-ын Кэмпбелсвил их сургуулийн магистрантурт нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр, Батсуурь овогтой Батцэцэгийг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт санхүүгийн чиглэлээр, Баасанжав овогтой Оюунцэцэгийг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын захиалгаар АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт програм хангамжийн чиглэлээр, Төмөр овогтой Батмөнхийг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар Англи улсын Лондонгийн Технологи, Менежментийн сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Халтар овогтой Болдмандалыг Байгаль орчны яамны захиалгаар Нью Саут Вэйлс их сургуулийн магистрантурт байгаль орчны эрх зүйн чиглэлээр, Сүх овогтой Түмэнжаргалыг Байгаль орчны яамны захиалгаар Нью Саут Вэйлс их сургуулийн магистрантурт байгаль орчны нөөцийн удирдлагын чиглэлээр, Содном овогтой Батсайхан, Цэдэвсоном овогтой Очгэрэл нарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Дотоод явдлын яамны Удирдлагын академид тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. ОХУ-ын Дотоод явдлын яамны Москвагийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Жаргалсайхан овогтой Мөнхболдын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу

00 0011

төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Н.Болормаа

Н.БОЛОРМАА